

МОБАЙЛ БАНКНЫ АМАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

20\_\_ оны \_\_ сарын \_\_ өдөр

Дугаар \_\_

хот/аймаг \_\_\_\_\_

Энэхүү гэрээг /цаашид “гэрээ” гэх/ нэг талаас ХасБанк /цаашид “банк” гэх/, нөгөө талаас \_\_\_\_\_ иргэний үнэмлэх, \_\_\_\_\_ регистрийн дугаартай \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ /цаашид “харилцагч”, хамтад нь “талууд” гэх/ нь ХасБанкны \_\_\_\_\_ салбарт байрших \_\_\_\_\_ тоот дансыг \_\_\_\_\_ дугаартай гар утсанд холбож Мобайл банкны үйлчилгээ авахаар дараахь нөхцөлдүүдээр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр банкнаас харилцагчид мобайл банкны АМАР үйлчилгээг /цаашид “АМАР үйлчилгээ” гэх/ үзүүлдэгтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2. Гэрээнд хэрэглэгдсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
  - 1.2.1. “Мобайл банкны АМАР үйлчилгээ” гэж харилцагч гар утас ашиглан шууд эсхүл агентар дамжуулан авч буй энэхүү гэрээний 2.3-т заасан үйлчилгээг;
  - 1.2.2. “АМАР үйлчилгээний данс” гэж харилцагчийн үйлчилгээнд бүртгүүлсэн Банкин дахь харилцах эсхүл хугацаагүй хадгаламжийн дансыг;
  - 1.2.3. “Нууц код” гэж харилцагч үйлчилгээг ашиглан дансны мэдээлэл авах, бэлэн бус гүйлгээ хийх бүрт хэрэглэгдэх дөрвөн оронтой тоог;
  - 1.2.4. “Гүйлгээ баталгаажуулах код” гэж харилцагч болон агент гүйлгээ хийх бүрт гүйлгээг баталгаажуулахын тулд үйлчилгээний системээс явуулж буй санамсаргүйгээр сонгогдсон гурван үсгийг;
  - 1.2.5. “Агент” гэж банктай хамтран АМАР үйлчилгээний бэлэн мөнгөний гүйлгээг дамжуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг;

ХОЁР. АМАР ҮЙЛЧИЛГЭЭ, ТҮҮНИЙ НӨХЦӨЛ

- 2.1. АМАР үйлчилгээний хүрээнд банк нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн эрхлэх хадгаламж, төлбөр тооцоо, эзэлийн үйл ажиллагааны тухай, Банкны тухай Монгол улсын хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд харилцагчтай харилцан тохиролцсоны дагуу энэхүү төлбөр тооцооны үйл ажиллагааг хүргэж байгаа болно.
- 2.2. Харилцагч нь гар утас ашиглан АМАР үйлчилгээг авахтай холбогдуулан доорхи нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн нь энэхүү үйлчилгээг үзүүлэх үндэслэл болсон болно.
  - 2.2.1. Нууц код, гүйлгээ баталгаажуулах код, гар утасны мессежийн утга нь харилцагч өөрөө банкинд хандан гаргасан холбогдох хүсэлт, төлбөр тооцооны баримтын бүрдүүдбэр, төлбөр тооцооны баримтад зурсан гарын үсэг, санхүүгийн болон бусад тамга, тэмдэгтэй нэгэн адил тооцогдоно.
  - 2.2.2. Үйлчилгээтэй холбоотой банкнаас өгсөн заавар, нууц код, баталгаажуулах код, гүйлгээний код зэргийг бусдад алдсан, ашиглуулсан, эсхүл тийнхүү ашиглуулах боломж олгосон зэрэг тохиолдолд түүнээ үүссэн үр дагаварыг бие даан хариуцна.
  - 2.2.3. Банк энэхүү гэрээний 2.2.1 болон бусад хэсэгт заасан бүрдүүдбэрийг үндэслэн гүйлгээг шууд хийх бөгөөд харилцагч эдгээр мэдээлээ бусдад алдсан, гүйлгээ хийх боломж олгосноос үүсэх үр дагаварыг өөрөө хариуцна.
- 2.3. Банк нь АМАР үйлчилгээг дараахь үйлчилгээг үзүүлнэ:
  - 2.3.1. Дансны үлдэгдэл шалгах;
  - 2.3.2. Сүүлийн 3 гүйлгээний мэдээлэл шалгах;
  - 2.3.3. АМАР үйлчилгээнд бүртгүүлсэн данс хооронд шилжүүлэг хийх;
  - 2.3.4. Үйлчилгээг байгууллагод төлбөр төлөх;
  - 2.3.5. Өөрийн данснаас бэлэн зарлага гаргах;
  - 2.3.6. Өөрийн дансанд бэлэн орлого хийх;
- 2.4. Үйлчилгээг ашиглахтай холбоотой “Мобайл банкны АМАР үйлчилгээний гарын авлага” /ХасБанк Маягт 43406-13/-ыг банк энэхүү гэрээг байгуулахад харилцагчид хүлээлгэн өгсөн болно. АМАР үйлчилгээнд орсон аливаа өөрчлөлттэй холбоотой заавар, мэдээллийг Банк өөрийн салбар, тооцооны төв болон агентар дамжуулан эсхүл мессеж, вэб хуудас дахь мэдээлэл хэлбэрээр үйлчилгээний холбогдох шатанд мэдэгдэх ба үүнийг мөн үйлчилгээтэй холбоотой заавар гэж ойлгоно.
- 2.5. Харилцагч нь энэхүү гэрээний 2.4-т заасан гарын авлагатай нэг бүрчлэн танилцаж, тэдгээрт заасны дагуу үйлчилгээг авах үүрэгтэй. Гарын авлагад тусгаагүй үйлчилгээг банк үзүүлэхгүй бөгөөд тэдгээрт дурдсан асуудлын агуулга, үе шатыг бүрэн буюу эсэргэцлэн ойлгоогүй тохиолдолд үйлчилгээг авахаас татгалзаж банкинд хандан нэмэлт мэдээлэл, тодруулга авсны дараа холбогдох үйлчилгээг ашиглах үүрэгтэй.
- 2.6. Банк нь үйлчилгээг харилцагчийн хүсэлтээр монгол эсхүл англи хэлээр үзүүлнэ. Харилцагч өөрийн англи хэлний мэдэлгийн түвшингээ хамааран үйлчилгээний явцад солилцож буй мэдээлэл, гарын авлага зэрэгт дурдсан үг, өгүүлбэр, агуулгыг ойлгоогүй тохиолдолд энэ гэрээний 2.5-д заасны дагуу банкинд хандан тодруулах, эсхүл Англи хэлээр мэдээлэл авах сонголтыг хийхгүй байх үүрэгтэй.
- 2.7. Банк харилцагчийн АМАР үйлчилгээний данс дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл багтаан төлбөр тооцоог гүйцэтгэнэ. Харилцагчийн дансны үлдэгдэл нь тухайн гүйлгээг хийхэд хүрэлцэхгүй, бүрдүүдбэр дутуу, өгөгдөл буруу зэргээс шалтгаалан гүйлгээ саатсаны улмаас учирсан үр дагавар, хохирлыг банк хариуцахгүй.
- 2.8. Үйлчилгээний жилийн хураамж, гүйлгээний шимтгэлийн хэмжээ, нэг өдөрт хийх гүйлгээний тоо болон дунгийн хязгаар зэргийг Банкны “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл” /цаашид “үйлчилгээний ерөнхий нөхцөл” гэх/-өөр тогтоох бөгөөд банк үйлчилгээний ерөнхий нөхцөлийг харилцагчид урьдчилан мэдэгдэхгүйгээр өөрчилж болно.
- 2.9. АМАР үйлчилгээг авахаар харилцагчийн илгээсэн мессежийн төлбөр нь түүнийг мессеж илгээсэн тухай бүрт тооцогдох харилцагчийн гар утасны нэгжээс хасагдана.
- 2.10. Банк нь харилцагчийн АМАР үйлчилгээгээр хийх төлбөр тооцоог дараахь цагийн хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:
  - 2.10.1. Улаанбаатарын цагаар Даваа-Ням гарагуудад 24.00-04.00 цагуудаас бусад цаг ирсэн гүйлгээний хүсэлтүүд банкны үндсэн системд шууд гүйцэтгэгдэнэ.
  - 2.10.2. Улаанбаатарын цагаар Даваа-Ням гарамын 04.00-09.00 цагуудад ирсэн гүйлгээний хүсэлтүүдийг дараагийн өдрөөр тооцож гүйцэтгэнэ.
  - 2.10.3. Нийтээр амрах баярын өдрүүдэд ирүүлсэн гүйлгээний хүсэлтийг гүйцэтгэхгүй.
- 2.11. Энэхүү гэрээнд тусгаагүй АМАР үйлчилгээний нөхцөл, журмыг тухайн үйлчилгээг үзүүлэх явцад хэрэглэгдэж буй маягт, АМАР үйлчилгээг авах хүсэлт, тухайн үйлчилгээг үзүүлэх

бусад шатанд банкнаас илгээж байгаа мэдээлэл, гарын авлага зэргээр тогтоосон гэж үзэх бөгөөд тэдгээр баримт бичгүүд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Энэхүү гэрээгээр банк дараахь эрхийг эдэлнэ:
  - 3.1.1. Үйлчилгээний ерөнхий нөхцөлд заасны дагуу харилцагчаас үйлчилгээний хураамж, шимтгэлийг бэлэн болон харилцагчийн АМАР үйлчилгээнд бүртгүүлсэн данснаас бэлэн бусаар авах;
  - 3.1.2. харилцагч энэхүү үйлчилгээний эрхээ халах хүсэлт гаргасан тохиолдолд банк харилцагчийн төлсөн жилийн хураамжийг эргүүлэн олгохгүй;
  - 3.1.3. хууль тогтоомжид заасан бусад эрх.
- 3.2. Энэхүү гэрээгээр банк дараахь үүрэг хүлээнэ:
  - 3.2.1. харилцагчийн гарын авлагад заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх;
  - 3.2.2. харилцагчийн хүсэлт нь банкнаас шалтгаалан биелэгдээгүй бөгөөд гар утасны нэгж нь суутгагдсан бол суутгагдсан нэгжийг төгрөгөөр тоцон харилцагчийн дансанд бэлэн бусаар шилжүүлэх;
  - 3.2.3. банк нь харилцагчийн дансны нууцыг хадгалж, гүйлгээний болон бусад хувийн мэдээллийг Монгол Улсын хууль, тогтоомжид зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй байх;
  - 3.2.4. харилцагчийг үйлчилгээний гарын авлагаар хангах;
  - 3.2.5. Банкны буруутай үйл ажиллагааны улмаас харилцагч, агентын хооронд үүссэн маргаантай асуудлыг гурван талын орлоотойгоор шийдвэрлэх;
  - 3.2.6. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.
- 3.3. Харилцагч энэхүү гэрээгээр дараахь эрх эдэлнэ:
  - 3.4. энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэх, гэрээгээр хүлээсэн үүрэг биелүүлэхийг банкнаас шаардах;
  - 3.5. өөрийн дансны үлдэгдэл, АМАР үйлчилгээгээр хийсэн төлбөр тооцоо, үйлчилгээтэй холбоотой асуудлаар банкнаас тайлбар авах;
  - 3.6. салбар, тооцооны төвд өөрийн биеэр хүрэлцэн ирж АМАР үйлчилгээгээр хийсэн бэлэн бус гүйлгээний баримт болон АМАР үйлчилгээнд бүртгүүлсэн дансны сүүлийн нэг сарын хуулгыг нэг удаа үнэ төлбөргүй хэвлүүлсэн авах;
  - 3.7. АМАР үйлчилгээний агентар дамжуулан бэлэн гүйлгээ хийсэн тохиолдолд агентад бэлэн мөнгө хүлээлгэн өгсөн эсхүл агентаас бэлэн мөнгө хүлээн авсан баримтыг гүйлгээ хийсэн тухайн агшинд агентаас авах;
  - 3.8. үйлчилгээний хугацаа дуусахад эрх сунгах, бүртгүүлсэн дансны болон үйлчилгээний мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, хаах хүсэлтийг банкинд бичгээр гаргаж шийдвэрлүүлэх;
  - 3.9. хууль тогтоомжид заасан бусад эрх.
- 3.10. Харилцагч энэхүү гэрээгээр дараахь үүрэг хүлээнэ:
  - 3.10.1. Банкны үйлчилгээний ерөнхий нөхцөлд заасан мөнгөн хөрөнгийг өөрийн дансанд байршуулж, үйлчилгээний үнэ, хураамж, шимтгэлийг үл маргах журмаар төлөх;
  - 3.10.2. үйлчилгээг гарын авлагад заасны дагуу хүсэлт илгээж авах бөгөөд гарын авлагад зааснаас өөрөөр хүсэлт ирүүлсний улмаас үүссэн хохирлыг бүрэн хариуцах;
  - 3.10.3. энэхүү гэрээнд заасан нууц код, баталгаажуулах кодыг бусдад дамжуулахгүй байх бөгөөд дамжуулснаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;
  - 3.10.4. үйлчилгээнд бүртгүүлсэн гар утасны дугаар, дансны дугаар өөрчлөгдсөн болон нууц кодыг алдсан тохиолдолд банкинд нэн даруй мэдэгдэх ба банкинд мэдэгдээгүйгээс буюу мэдэгдээс өмнө үүссэн аливаа асуудлыг хариуцах;
  - 3.10.5. харилцагч нь Банкны салбар, тооцооны төв байршдаггүй сум орон нутгийн агентар дамжуулж АМАР үйлчилгээний эрх нээлгэсэн бол Банкнид бүртгүүлсэн нууц кодоо анхны хүсэлтээр солих;
  - 3.10.6. үйлчилгээг ашиглан АМАР үйлчилгээний дансандаа бэлнээр орлого, зарлагын гүйлгээ хийх тохиолдолд иргэний бичиг баримттайгаа ирнэ;
  - 3.10.7. нууцшалыг хангах үүднээс гар утаснаасаа АМАР үйлчилгээг авахаар илгээсэн хүсэлт болон Банкнаас хүлээн авсан хариу мессежийг гүйлгээ хийгдсэн тухай бүрт устгах. Ийнхүү устгаагүйгээс нууц код болон дансны мэдээлэл бусдад алдсанаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;
  - 3.10.8. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 4.1. Энэхүү гэрээ 20\_\_ оны \_\_ сарын \_\_ өдрийг хүртэл \_\_ жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 4.2. Харилцагч энэхүү гэрээнд заасны дагуу АМАР үйлчилгээний жилийн хураамжийг төлөөгүй, үүссэн бусад тооцоог барагдуулаагүй тохиолдолд банк үйлчилгээний хугацаа дууссан өдрөөс хойш нэг сарын хугацаанд түгэлзүүлэх бөгөөд энэ хугацааны дотор харилцагч хураамж, тооцоог барагдуулаагүй тохиолдолд банк энэ гэрээг нэг талын санаачилгаар цуцалж дуусгавар болгоно.
- 4.3. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 4.4. АМАР үйлчилгээний гарын авлага болон гэрээний хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 5.1. Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.
- 5.2. Гэрээтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.
- 5.3. Энэхүү гэрээний 5.2-т заасан журмаар маргааныг шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Банкийг төлөөлж: \_\_\_\_\_-р салбар, тооцооны төвийн Нягтлан бодогч \_\_\_\_\_

Харилцагч: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Тэмдэг

Хаяг